



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 59

Сүхбаатар сум

Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 31,772,200 (гучин нэгэн сая долоон зуун далан хоёр мянга хоёр зуу) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6,000,000 (зургаан сая) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Хүнс хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33,000,000 (гучин гурван сая) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Орхон сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 22,990,000 (хорин хоёр сая есөн зуун ерөн мянган) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 15,200,000 (арван таван сая хоёр зуун мянган) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Тээврийн удирдах газар байрлаж байсан 2002 онд аж ахуйн аргаар барьж ашиглалтанд оруулсан 12*6 хэмжээтэй 2 давхар модон барилга зэрэг нь цаашид сэргээн засварлах, ашиглах боломжгүй болсон тул хавсралтад дурдсаны дагуу дээрх тээврийн хэрэгсэл, барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоосугай.

2. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж явуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /П.Эрдэнэсайхан/-д даалгасугай.

ДАРГА  Г.БЯМБАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын
05-ны өдрийн 59 тоот тогтоолын хавсралт

Дуудлагын худалдаагаар худалдах үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Байгуулагын нэр	Хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн нэр, төрөл машины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд орсон он	Үйлдвэрлэсэн улс	Тоо ширхэг	Дансны үнэ	Элэгдлийн дүн	Үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	орон нутгийн өмчийн газрын санал	Засаг даргын санал	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн санал
1	Цагааннуур сумын ЗДТГ	Суудлын автомашин	Тойота Карина 93-06 СБА	1998	2007	ЯПОН	1.00	6,349,200.00	6,349,200.00	-	Агглах	1,000,000.00	1000.0	1000.0
2	Цагааннуур сумын ЗДТГ	Бага оврын автобус	Истана 77-24 СЭА	2003	2011	БНСУ	1.00	15,000,000.00	15,000,000.00	-	Агглах	2,000,000.00	2000.0	2000.0
3	Цагааннуур сумын ЭМТ	Суудлын автомашин	УАЗ-469 08-42 СБА	2005	2006	ОХУ	1.00	10,423,000.00	10,423,000.00	-	Агглах	1,000,000.00	1000.0	1000.0
	Дүн						3.00	31,772,200.00	31,772,200.00					
1	Баянгол сумын ЗДТГ	Бага оврын автобус	Истана 19-47 СЭУ	1997	2008	БНСУ	1.00	6,000,000.00	6,000,000.00	-	Агглах	1,500,000.00	1500.0	1500.0
	Дүн						1.00	6,000,000.00	6,000,000.00					
1	Хүнс хөдөө аж ахуйн газар	Суудлын автомашин	УАЗ-390992 18-74 СЭА	2012	2012	ОХУ	1.00	20,000,000.00	20,000,000.00	-	Агглах	2,500,000.00	2500.0	2500.0
2	Хүнс хөдөө аж ахуйн газар	Суудлын автомашин	Ниссан Фуго 00-18 СЭА	2004	2011	ЯПОН	1.00	13,000,000.00	13,000,000.00	-	Агглах	2,500,000.00	2500.0	2500.0
	Дүн						2.00	33,000,000.00	33,000,000.00					
1	Орхон сумын ЗДТГ	Суудлын автомашин	Тойота Корса 18-90 СЭА	1998	2008	ЯПОН	1.00	3,000,000.00	3,000,000.00	-	Агглах	500,000.00	500.0	500.0
2	Орхон сумын ЗДТГ	Ачааны автомашин	Исузу ELF 03-15 СЭУ	1998	2008	ЯПОН	1.00	19,990,000.00	19,990,000.00	-	Агглах	2,000,000.00	2000.0	2000.0
	Дүн						2.00	22,990,000.00	22,990,000.00					
1	Орхонтуул сумын Рашаант тосгоны ЭМТ	Суудлын автомашин	УАЗ-315122 19-34 СЭА	2009	2009	ОХУ	1.00	15,200,000.00	15,200,000.00	-	Агглах	1,000,000.00	1000.0	1000.0
	Дүн						1.00	15,200,000.00	15,200,000.00					
1	Хүлэг Зочид буудал, газрын хамт	Барилга					1.00	-	-	-	Агглах	20,000,000.00	20000.0	20000.0
	Дүн						1.00	-	-	-				
	Нийт дүн						10.00	108,962,200.00	108,962,200.00					

Орон нутгийн өмчийн газар